

## 13

## УЛААН БУУДАЙН ҮРИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

Д.Төмөрчөдөр

## Дэлхийн буудайн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, хэтийн төлөв

Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш ХАА. Үйлдвэрлэлийн салбарын уналт улам гүнзгийрч байгаа нь бизнесийн таатай орчин бүрдээгүй, микро болон макро түвшин дэхь менежмент, маркетингийн асуудал зөв голдиролдоо орж чадаагүйтэй холбоотой юм. Учир нь газар тариалангийн салбар нь 1990 он хүртэл зуун хувийн төрийн болон хоршооллын өмчид тулгуурласан төрөөс хатуу тогтоодог үнийн тогтолцоотой гадаадын зээлд дулдуйдсан зардал өндөртэй байлаа. Иймээс газар тариалангийн салбарын төрийн тэтгэлэг зогсож, чөлөөт зах зээлд шилжсэнээр уналтанд орж эхэлсэн олон хүчин зүйлүүдээс үрийн асуудлыг авч судлахын тулд дэлхийн буудайн үйлдвэрлэл, худалдаа, үнийн хандлагыг нарийн шинжлэн үзэх зайлшгүй шаардлага гарч ирж байгаа юм. Монгол орны хөрс цаг уурын байдал нь буудайн үйлдвэрлэл эрхэлдэг аль ч оронтой харьцуулах аргагүй муу. Шилжилтийн үеийн хямралаас шалтгаалан дотоодын үйлдвэрлэл эрс буурч импорт экспортын чадвар буурсан зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн буудай гурилын үйлдвэрлэлийн хандлагыг судалж үзэхгүйгээр дотоодын үйлдвэрлэлийн хандлагыг тодорхойлох аргагүй болж байгаа юм. Иймээс дэлхийн буудайн үр үйлдвэрлэл, экспорт, импорт, үнэ зэрэг НҮБийн статистикийн мэдээлэлд тулгуурлан судлаачид авч үзжээ. 1985-1995 онд дэлхийд дунджаар 1.5- 1.6 млрд тн үр тариа, үүнээс 580 сая тн буудай үйлдвэрлэж байгаа нь хүн төрөлхтний жилд хэрэглэдэг түүхий эдийн нөөцийн  $\frac{1}{6}$  орчим болж байна. Сүүлийн 90 жилд дэлхийн буудайн дундаж ургац 8.6 цн га-гаас 24 цн га хүртэл 2.7 дахин нэмэгдсэний 50 хувь бордоо хэрэглэснээс, 25 хувь нь шинэ сорт нэвтрүүлснээс, 25 хувь нь агро техникийн арга ажиллагааны төвшин дээшилснээс болсон гэж үздэг. (Walsh.E 1984)

Энэ нь дэлхийн буудайн үйлдвэрлэл, тариалах талбай, га-гийн ургацын олон жилийн үзүүлэлт, ялангуяа 1950-1990 оны өсөлтөөс тодорхой харагддаг. Гагцхүү энэ өсөлт нь манай орны хувьд ердөө 1980-1990 оны хооронд байсан бөгөөд 1990 оноос хойш их үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийхэд хэцүү болсон нь ойлгогдох шалтгаантай. Манай орны 1986-1990 онд га-гаас хураан авсан дундаж ургацаар буудайг 2-1- сая га талбайд тариалдаг Бразили, Португали, Иран, Австрали улсын төвшинд хүрсэн нь эрчимжүүлэлтийн дээрхи гурван хүчин зүйлээс болсон байна.

#### Дэлхийн улсуудын улаан буудайн ургац (цн| га)

Он \ Улс	1934-1938	1961-1965	1971-1975	1976-1980	1981-1985	1986-1990
Монгол	7,5	8,7	8,0	7,5	10,0	12,7
Хятад	10,09	10,3	15,1	18,5	26,5	28,0
Бразили	7,5	7,1	8,7	7,5	11,2	12,0
Канад	12,8	13,9	17,0	18,9	18,6	20,1
Иран	11,0	8,0	8,8	11,2	10,2	12,1
АНУ	11,2	17,0	20,6	21,5	24,9	28,7
ЗХУ(хуучнаар)	7,2	9,6	14,5	16,4	14,5	15,2
Энэтхэг	6,6	8,4	12,9	14,69	17,7	19,3
Австрали	7,9	10,0	12,3	12,7	13,7	14,1
Португали	7,9	10,0	12,3	13,0	13,4	12,2

#### Дэлхийн улсуудын улаан буудайн импорт (мян.тн)

Он \ Улс	1985	1986	1987	1988	1989	1990	1991	1992	1993
Хятад	7,5	8,2	15,2	17,0	14,6	11,0	16,1	7,6	6,9
Энэтхэг	0,2	0,1	0,3	2,0	0,1	0,2	0,1	3,1	0,2
Иран	2,0	2,4	4,0	3,1	5,3	4,0	3,6	3,0	3,5
Бразили	2,2	2,9	2,1	0,8	1,5	2,8	5,2	5,8	5,7
Хойд Америк	0,4	0,4	0,3	0,8	0,6	0,9	1,2	1,9	3,2
Европ	6,9	7,4	7,3	6,1	4,3	4,1	4,5	5,8	4,9
Осеаниа	0,3	0,3	0,4	0,3	0,4	0,4	0,4	0,4	0,5
Дэлхийд	8,6	87,2	104,9	96,3	94,7	90,5	108,0	102,6	94,4

#### Дэлхийн улсуудын улаан буудайн импорт (мян.тн)

Он \ Улс	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Хятад	8,8	14,3	13,5	11,85	7,25	7,85	11,55	12,65	9,5
Энэтхэг	0,1	0,1	0,15	1,6	1,65	0,15	0,1	0,125	0,87
Иран	3,2	3,3	3,8	3,3	3,75	5,12	3,55	3,52	4,22
Бразили	6,6	5,7	4	5,5	5,75	6,1	4,85	5,65	5,92
Хойд Америк	2,4	1,8	1,5	1,55	2,55	2,8	2,1	1,65	1,525
Европ	4,3	5,4	4,3	5,15	5,35	4,6	4,85	4,7	5,2
Осеаниа	0,4	0,4	0,4	0,4	0,45	0,45	0,4	0,425	0,45
Дэлхийд	91,5	93,8	99,25	105,3	107,5	92,9	92,6	96,5	102,7

#### Дэлхийн улсуудын улаан буудайн экспорт (мян.тн)

Он \ Улс	1985	1986	1987	1988	1989	1990	1991	1992
Хятад	-	-	-	-	-	-	-	-
Энэтхэг	0,3	0,5	-	-	-	0,7	0,7	-
Канад	16,7	20,8	23,6	13,6	17,0	20,7	23,6	21,7
АНУ	24,8	28,3	43,4	37,6	33,5	28,3	35,1	37,1
Аргентин	6,1	4,3	3,8	3,5	5,6	3,7	5,6	7,0
Европ	18,5	19,2	17,1	24,7	24,7	21,4	24,6	22,5
Австрали	16,1	14,8	12,2	10,7	11,9	12,3	8,2	9,5
Дэлхийд	85,3	90,8	105,8	96,5	96,8	92,3	106,9	104,0

#### Дэлхийн улсуудын улаан буудайн экспорт (мян.тн)

Он \ Улс	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Хятад	-	-	-	-	-	-	-	-	-	-
Энэтхэг	-	0,2	1,2	2,2	3,2	4,2	5,2	6,2	7,2	8,2
Канад	18,6	21,2	17,2	37,2	4,2	49,2	53,2	61,2	65,2	69,2
АНУ	33,1	32,2	33,5	35,8	37,1	38,4	39,7	41	42,3	43,6
Аргентин	3,9	7,9	4,2	4,6	14,3	6,3	5,45	11,8	6,05	4,4
Европ	20,1	20,3	18,8	17,3	15,8	14,3	12,8	11,3	9,8	8,3
Австрали	12,9	7,9	12,1	10,2	8,9	11,2	10,4	10,0	6,56	9,55
Дэлхийд	93,2	94,7	90,0	99,6	105,4	98,6	94,0	92,3	94,8	102,5

Ургацыг нэмэгдүүлэх хүчин зүйлийн нөлөөнд таримлын төрөл, сорт, агроэкологийн нөхцөл, агротехникээс хамаарч тодорхойлоход төвөгтэй байдаг боловч зүйл тогтлыг шинжлэн дүгнэж болдог. (Morgan.S 1991)

Сүүлийн үеийн мэдээгээр дэлхийн улсууд 690 гаруй сая га-д үр тариа тариалж, 1,9 тэрбум тн ургац авч байна. Энэ нь дэлхийн 4,594 тэрбум хүний нэгд нь 124 кг буудай оногдож байна. Иймээс АНУ, Канад, Австрали, Франц, Англи, Аргентин, Чех, Герман, Турк, Унгар зэрэг буудай их хэмжээгээр тариалдаг цөөн хэдэн оронд буудай илүүдэлтэй байхад бусад 80 гаруй оронд дутагдалтай байна.

Буудай нь дэлхийн нийт үр тарианы ургамлын 30 хүрэхгүй хувийг эзэлдэг боловч өөр ямарч ургамалд байхгүй амин дэмүүд байдаг нь түүний үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагыг бий болгож байгаа юм. Гэвч дэлхийн хүн ам өсч хот суурин газрууд хүрээгээ тэлж байгаа мөн тариалангийн талбайн хэмжээ жилээс жилд буурах хандлагатай байна. Тухайлбал: Дэлхийн хэмжээгээр 1989 онд үр тариаг 780,2 сая га-д тариалж, үүнээс 226,7 сая га-д буудай тариалж байсан бол 1995 онд 692,8 сая га-д үр тариа тариалж 220,9 сая га-д буудай тариалах болж үр тариа тариалсан талбай 5,8 сая га-гаар буурсан байна. Энэ нь жил тутам үр тарианы талбай 3,08 сая га-гаар буурч байна гэсэн үг.

Харин буудай тариалах талбайн бууралт нийт үр тарианыхаас бараг 2 дахин бага байгаа нь уг таримал хүнсний нэн өндөр эрэттэй таримал болохыг харуулж байна. (Н.Алтансүх)

Үр тариа, буудай тариалсан талбай (сая га)

Таримал	1989	1990	1991	1992	1993	1994	1995	Өссөн хувь
Үр тариа	708,2	703,0	697,8	707,5	697,1	698,1	692,8	3,08
Буудай	226,7	231,7	223,1	222,2	222,6	220,9	220,9	1,16

Үр тариа, буудайн ургац (сая га)

Таримал	1989	1990	1991	1992	1993	1994
Үр тариа	1983.0	1970.0	1879.0	1969.0	1902.0	1957.0
Буудай	543.0	601.0	546.0	546.0	565.0	526.0

Үр тариа, буудайн ургац (сая га)

Таримал	1995	1996	1997	1998	1999
Үр тариа	1909.0	2083.0	2102.0	2058.0	2000.0
Буудай	546.0	589.9	615.4	594.0	600.0

Тариалах талбайн хэмжээ ийнхүү эрчимтэй буурч байхад хураан авсан ургац нь 1999 оныг 1989 онтой харьцуулахад үр тарианд 4,4 хувиар, буудайных 9,4 хувиар нэмэгдсэн байгаа нь газар тариалангийн эрчимжилт илүү хурдацтайг харуулж байна.

## 2. Монгол орны буудайн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал

Монгол орны хувьд 1920-иад оноос газар тариалангийн ач холбогдол аажмаар дээшлэн 192 онд 10 мянган га 1941 онд 20,6 мянган га газарт тариалан эрхлэх болжээ. 1921 онд Сэлэнгэ аймагт Хараагийн тариалангийн сан байгуулсныг САА-ын анхны үүсэл гэж үздэг. 1930 оноос атар газар эзэмших том арга хэмжээг явуулсан нь үр дүнд хүрч газар тариаланд нэлээд эрчимтэй үйлдвэрлэл явуулахад хүргэжээ. Атар газар эзэмших анхны арга хэмжээг хэрэгжүүлэх ажилд шаардагдах мэргэжилтэй олон мянган ажилчдыг бэлтгэхэд ихэд анхаарч байсан, 1960-аад оноос газар тариалангийн үйлдвэрлэл манай улсын ХАА-н биеэ даасан салбар болсон нь хүн амыг тодорхой төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр, МАА гахай, шувуу зэрэг туслах аж ахуйг тэжээлээр хангахад чухал нөлөө үзүүлсэн юм.

Газар тариалангийн үйлдвэрлэл манай оронд эрчимтэй хөгжиж эхэлсэн энэ үеэс (1960) гол нэр төрлийн таримлын талбай байнга нэмэгдэж байлаа. Тухайлбал үр тарианы талбай 1961-1965 онуудад (57,76 хувь), 1976-1980 онуудад (43,33 хувь) тус тус огцом өсчээ. 1990 он хүртэл эргэлтийн талбай 1,3 сая га-д хүрч үр тариа дундажаар 770-830,0 мянган тн-г хураан авч дотоод хэрэгцээг бүрэн хангаад илүүг нь экспортлож байсан.

Тариалалтыг 12-14 хоногт тариа хураалтыг 30-35 хоногт тус тус (А.Хүчит) багтаан гүйцэтгэх техникийн хүчин чадалтай болсны гадна өөрийн орны байгаль, цаг уурын, хөрсний нөхцөлд тохирсон үйлдвэрлэлийн технологи, таримлын сорттой болж олон мянган агрономчид, эдийн засагчид инженер техникчдийн бүхэл бүтэн үеийг бий болгосон юм.

Манай оронд өрнөсөн нийгэм улс төр, эдийн засгийн шинэчлэл өөрчлөлтийн явцад тохиолдож буй хямрал бэрхшээлд бусад салбарын нэгэн адил нэрвэгдэж 1991 оноос үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйнууд олон жижиг компани, фермерийн аж хауй болсноор өөрийн нөхцөлд тохирсон үрийг сонгон авч тариалж чадахгүй байгаа ба үрийг 2,4- 26,7 жил солилгүй тариалах, (Л.Наранхүү) тариалж байгаа талбайн хэмжээ 2,5-3 дахин буурах, улсын үрийн аж ахуйн систем задарч улс орны тариалангийн бодлого алдагдаж үр солих шинэчлэх ажил орхигдож тарих үрийн чанар кондицийн шаардлагад тэнцэхгүй болсноор үр тарианы голлох таримлын нэг буудайн ургац 1990 онд 11,2 цн/га хүртэл буурчээ.

Онууд 1га-н ургац	1986	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	цаашид
	1990										
Буудай	12,7	10,4	8,6	8,9	7,5	7,3	6,8	7,5	6,4	6,1	11,7-14,0

Монголын газар тариаланг хөгжүүлэх чиглэлийг засгийн газар мөрийн хөтөлбөртөө тусгаж гадаад дотоодын хөрөнгө оруулалт болон санхүүжилт менежментийн талаар тодорхой ажилуудыг зохиож эхлээд байна. Үүний нэг нь 2000-2005 онд хэрэгжүүлэх "ҮР" дэд хөтөлбөр болно.

### Буудайн үрийн эрэлт, өнөөгийн байдал

Монгол орны газар тариалангийн бүс нутаг бүрт үр тарианы ургацыг тогтворжуулах, түүнийг нэмэгдүүлэх чухал хүчин зүйлийн нэг нь орон нутгийн байгаль цаг уурын нөхцөлд зохицсон арвин ургацтай сортууд юм. Ургацын өсөлтийн 15-20 хувь нь сайн чанарын сортын үрээр тариалснаас шалтгаалдаг гэж үздэг. Манай улсад 2005 оны хаврын тариалалтаар нийт 218 мянган га-д буудай тариалахаар төлөвлөж байна. Үүнээс 116,256 мянган га уриншид буудай тариалж, 102,256 мянган га-д гуурсанд тариална гэж үзэж байна. Улсын нөөцөөс одоогийн байдлаар 13000 тн үр гаргах боломжтой байна. Үүнээс үрийн буудайн зах зээлийн үнэ 1 тн-г 200000 төгрөгөөр худалдаалж байна. Судалгаанаас үзэхэд үрийн нийлүүлэлт хаврын тариалалтын үеэр нь дутагдалтай байгаа нь харагдлаа. Иймд дутагдах үрийг хангахын тулд ОХУ, Казакстан зэрэг орнуудаас манай оронд нутагшсан тариалах боломжтой "Саратов-29", "Бурятская-34", "Скала", "Сэлэнгэ" сортуудын үрийг оруулж ирэх хэрэгцээ шаардлагатай байна. Одоогийн байдлаар "Саратов-29" сортын үрийг 2001 оны тариалалтад хэрэглэхээр 1 тн-г нь 250000 төгрөгөөр үнэлэн ААН, компаниудад худалдаалж эхлээд байна. Гэвч энд үрийн чанар, үнэ, компаний худалдан авах чадварын талаар анхаарахгүй бол тариалалтын талаар яриад ч хэрэггүй болно. Газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд сорт түүний элит үр чухал үүрэгтэйг харгалзан Засгийн газраас 1982 онд "ХАА-н таримлын үрийн аж ахуйг сайжруулах" тогтоол гаргаж үр тариа, төмс хүнсний ногоо, тэжээлийн байгууллагууд үйлдвэрлэж 5 жил тутуам сортын шинэчлэл хийж байсны үр дүнд гол таримал болох буудайн дундаж ургац 1985-1990 онд 12,7 цн/га хүрсэн гэж үздэг. Гэтэл сүүлийн жилүүдэд эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан үр шинэчлэл хийгдээгүй, үрийн олдоц чанар муудснаас ургац 2000-2004 оны байдлаар 6,1 цн/га хүртэл буураад байна. Манай орон зах зээлийн

эдийн засагт шилжснээс хойш үнийг төрөөс зохицуулж байсны үр дүнд буудайн үнэ харьцангуй тогтвортой байна.

Буудайн үнэ /мян.төг/

Он	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	2000-2005
Үнэ	0.9-1.2	6.5-7.0	37.0-43.0	28.0-36.0	55.0-60.0	90.0-95.0	100.0-110.0	110.0-120.0	230-250

Хүснэгтээс үзэхэд 1995-1997 онд буудайн үнийн өсөлт хурдтай нэмэгдэж, сүүлийн 3 жилийн дунджаар авч үзвэл жилийн дундаж өсөлт 6,6 мянган төгрөг болсон байна. 1991 оноос 2005 оны тоо баримтад тулгуурлан буудайн эрэлт нийлүүлэлтийн байдлыг үзвэл эрэлтэнд тухайн бараатай уядаатай барааны үнэ хүн амын өсөлт, орлого, үндэсний зан заншил, амьдралын хэвшлийн онцлог, харин нийлүүлэлтэнд тухайн барааны үнэ, үйлдвэрлэлийн технологи, орлох чадвартай барааны үнэ, зах зээлийн бүтэц зэрэг олон хүчин зүйл нөлөөлнө. Эдгээрээс хамгийн гол нөлөө үзүүлдэг зүйл бол тухайн барааны үнэ юм. Барааны үнэ их өсч, инфляци өндөр байгаа нөхцөлд үнийн өөрчлөлтийг тооцоонд тусгах шаардлагатай байдаг.

### 2005 оны үрийн хэрэгцээг тооцох (Улсын дүнгээр)

Бүс	Сортын нэр	Эзлэх хувь	Талбай [га]	1 га-н үрийн норм [кг/га]	Нийт үрийн хэрэгцээ		Үрийн сангийн нөөц
					Кг	Тн	
Баруун	Альбидум-43	80	3769	100	37690	377	75,4
	Скала	20	942		94200	94	18,8
Төв	Бурятская-34	65	186607	200	37321400	37321	7464,2
	Орхон	15	43063		8612600	8613	1722,6
	Альбидум-43	8	22967		4593400	593	918,6
	Скала	7	20096		4019200	4019	803,8
	Халх гол -1	5	1435		2870800	2871	57,2
Зүүн	Халх гол-1	50	11151	200	2230200	2230	446
	Орхон	0	8921		178200	178	356,8
	Саратовская-29	10	2230		446000	446	89,2
Нийт		100	314100		62348900	6238	12470

Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрхлэх үйл ажиллагааны нэгдмэл систем нь тухайн орныхоо нийгэм эдийн засгийн хөгжил, аж ахуй зохион байгуулалт, байгаль цаг уурын нөхцөл, техник технологийн боломж, чадавхаас ихээхэн хамаардаг. Тариалангийн систем нь тариалагдаж байгаа таримлын бүтэц, тэдгээрийн технологийн онцлог, газар ашиглалтын төвшин, тариалангийн бүтээгдэхүүний ашиглалтын чиглэл, зэрэг үзүүлэлтээр ялгарах бөгөөд дээр дурьдсан үзүүлэлтээр нь тариалангийн системийн

хөгжлийн төвшинг тодорхойлдог юм. Тухайлбал: газар тариалангийн хөгжлийн илтгүүр нь газар ашиглалт юм.

Техник технологийн шинэчлэлт нь газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах нэг хүчин зүйл болдог. Улс орон зах зээлийн харилцаанд шилжиж байгаа нөхцөлд тариалан эрхлэх аж ахуй, зохион байгуулалтын арга үндсээрээ өөрчлөгдөж үүнийг дагаж техник технологио ч боловсронгуй болгох бодит шаардлага тавигдаж байна. 2002 оныг 1992 онтой харьцуулбал тариалангийн төв бүсийн компаниудын траектор, комбайны тоо 2,6 дахин цөөрч нийт техникийн 70-80 хувь нь хуучирч элэгдэн технологийн шаардлага хангахгүй байна. Иймээс техникийн шинэчлэл хийхгүйгээр газар тариаланг сэргээх, эрчимжүүлэх боломжгүй юм.

Монгол орны нутаг дэвсгэр төв азийн өндөр уулсуудын хооронд далайн төвшнөөс дээш дунджаар 1580 км өргөгдсөн их газрын эрс тэрс уур амьсгалтай мужид оршдог онцлог нь газар тариалангийн үйлдвэрлэлийн гол бүтээгдэхүүн болох буудайн ургацад шийдвэрлэх нөлөөтэй. Энэхүү нөлөөллийг гүйцэд тооцоогүйгээс таримлын ургац буурах, алдах явдал ажиглагдлаа. Манай орны агро цаг уурын онцлог нь удаан үргэлжилдэг хүйтэн өвөл, сэрүүхэн зун, бага хур тунадас, температурын өндөр хэлбэлзэл, жилд харьцангуй олон нартай өдөр байдаг зэрэг шинжүүд илэрнэ. Жилийн хамгийн хүйтэн сар нь нэгдүгээр сар байдаг бөгөөд дундаж температур нь -15 хэмээс -35 хэм, зарим тохиолдолд -50 хэм хүртэл хүйтэрнэ. Жилд хамгийн халуун сар нь долдугаар сар бөгөөд дундаж температур нь +15 хэмээс +25 хэм, хамгийн их утга нь +35 хэмээс +43 хэм хүрэх тохиолдол ч бий. 1999 оны 7 сар нь байнгын багажийн ажиглалт хийсэн сүүлийн 60 жилд ажиглагдаагүй халуун сар болсон. Чийгийн хангамж боломжтой зарим газар нутагт дулаан дутмаг байдаг. Энэ нь газар тариалангийн үйлдвэрлэлийг газар сайгүй эрхлэх боломжийг хязгаарлах нөхцөл болдог. Гэрэл дулаан ба чийгийн хангамжийн тодорхой төвшинд арвин ургац бүрэлддэг боловч манай орны хувьд ийм нөхцөл бүрдэх нь судалгаанаас үзэхэд ховор байна. Буудайн ургалт удаашрах, ургац буурах гол нөхцөл нь ургалтын эхний үед хур тунадас бага унаж хөрсний чийг дутмаг бадагт оршино.